



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/23

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Ховд хотын ундны усны 2 дахь эх үүсвэрийн зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл хийх /Жаргалант сум/ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ж.Батсайхан - "Тогтвортой амьжиргаа" төслийн зохицуулагч

Гишүүдэд: Ц.Бат-эрдэнэ - Хот тохижуулах газрын мэргэжилтэн
н.Соёл-Эрдэнэ - Төрийн бус байгууллагын төлөөлөл
М.Отгонцэцэг - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Б.Бурмаа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ж.Батсайхан/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Б.Бурмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД